

Улаанбаатар хот дахь хүүхэд, өсвөр насныхны эсрэг бэлгийн хүчирхийллийг судлах асуудалд

Го-Ва В., Минжмаа Э., Оюунсүрэн Д., Хишигсүрэн З.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Анагаах ухааны сургууль
minjee_51@yahoo.com

Abstract

Sexual violence against child and adolescents in Ulaanbaatar

Gou Wang W., Minjmaa E., Oyunsuren D., Khishigsuren Z.

Mongolian national university of medical sciences, School of medicine
minjee_51@yahoo.com

Introduction

Violence is defined by the WHO as “the intentional use of physical force or power, threatened or actual, against oneself, another person, or against a group or community, which either results in or has a high likelihood of resulting in injury, death, psychological harm, maldevelopment, or deprivation”. Violence can be divided into many types such as physical, psychological, sexual, neglect and economical etc. Violence against women and child is a manifestation of historically unequal power relations between men and women or child due to patriarchy in many countries of the world. Child maltreatment or violence is one of common public health problems in worldwide and psychologically harm in child’s later life.

Objective

To detect types, percent and some influencing factors of violence against child and adolescent among cases, which were involving into forensic psychiatric evaluation procedures.

Materials and Methods

We are analyzed all archive documents of NCMH, 2000-2014 by retrospective methodology on based ethical approval of NCMH administration (by ordering 2/189 Oct 28, 2015).

Results

Total 1067 cases of violence against child and adolescent were registered in 2000-2014 years and 84.7 percent of those (n=904) were sexual violence cases. Gender difference was defining among sexual violence cases (girls n=885, p<0.000; boys n=19, p<0.000) with statistically significant. Sexual offender can be act his violence in drunken (OR=2.355; p<0.000; CI 95%; 1.601-3.463) or negative relationship between family members (OR=3.723; p<0.000; CI 95%-2.356-5.883) are more influenced to sexual violence against child and adolescent.

Conclusion

Sexual violence is more registered among child and adolescent maltreatment cases. Children and adolescents are more affected into sexual violence likely to have a negative relationship between the family members or offenders have used alcohol.

Key words: Children, teens, maltreatment, sexual abuse, forensic psychiatry.

Pp. 63-69, Tables 3, Figures 4, References 14

Оршил

1989 онд батлагдсан Хүүхдийн эрхийн конвенцийн 19-р зүйлд “Хүүхэд бүр эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч болон хүүхдийн төлөө анхаарал халамж тавих бусад хүмүүсийн зүгээс

хүчирхийлэл, хайхрамжгүй харьцах зэрэг бүх хэлбэрээр эрхээ хамгаалуулах эрхтэй” гэж заасан бол “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” Монгол улсын хуулийн 5.2-д “Хүүхэд эрүүл мэнд өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, хүчирхийллээс ангид байх эрхтэй” гэжээ [1, 2].

Хүчирхийлэл гэж “Хэн нэгэн субъект өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд аль нэг давуу талаа ашиглан бусдын эрх ашгийг хохироохыг хэлнэ” [3].

Хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн, үл хайхрах хүчирхийлэл зэрэг олон хэлбэртэй байдаг бөгөөд хүчирхийлэлд хэн өртөж байгаа байдлаараа гэр бүлийн хүчирхийлэл, настны эсрэг, хүүхдийн эсрэг, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл зэргээр ангилагддаг байна [3].

Дэлхийн бараг бүх улс оронд эцгийн эрхт ёс ноёрхож байгаатай холбоотой хүчирхийлэл, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл амь бөхтэй [4]. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудал нь дэлхий дахинаа нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болсон төдийгүй хүүхдийн хожмын амьдралд сэтгэлзүйн хоруу чанар ихтэй үзэгдэл мөн [5].

ДЭМБ-ын судалгаагаар (2000) жил тутам 15 хүртэлх насны 57000 хүүхэд хүчирхийлэлд өртөж амиа алддаг бөгөөд үүний дотор 0-4 насны хүүхдийн эзлэх хувь өндөр байдаг ажээ [6].

Манай улсад бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж буй хүүхдийн тоо нэмэгдэж байна гэдгийг олон байгууллагууд хүлээн зөвшөөрөх боллоо [7, 8].

Дэлхий дахинаа хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн тохиолдол хамгийн өндөр улсын тоонд Өмнөд Африк, Энэтхэг, Зимбабве, Их Британи, АНУ оржээ [9].

Манай улсад хийсэн судалгаа нь хүүхдийн эсрэг, гэр бүлийн доторх хүчирхийллийн асуудалд чиглэгдсэн байх бөгөөд хүүхдийн эсрэг хүчирхийллийг шүүхийн сэтгэц гэм судлалын

асуудалтай холбон судалсан судалгаа үгүй байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон юм.

Зорилго

Улаанбаатар хот дахь хүүхэд, өсвөр насныхны эсрэг бэлгийн хүчирхийлэл, түүнд нөлөөлөх зарим хүчин зүйлсийг судлан тогтооход оршино.

Зорилт:

1. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээнд хамрагдагсдын хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн байдлыг судлан тогтоох
2. Хүүхэд, өсвөр насныхны эсрэг хүчирхийллийн дотор бэлгийн хүчирхийллийн эзлэх хувийг судлан тогтоох
3. Хүүхэд, өсвөр насныхан бэлгийн хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийг судлан тогтоох

Материал, арга зүй

Судалгааг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн архивт хадгалагдан буй 2000-2014 оны шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээний 160 хавтас материалд эргүүлэн судлах аргаар баримтын судалгаа хийсэн. Судалгааг хийхийн тулд СЭМҮТ-өөс ёс зүйн зөвшөөрлийг (2015.10.28-ны өдрийн 2/189 тоот) авсан. Баримтын судалгааг 2015 оны 11 дүгээр сараас 2016 оны 1 дүгээр сар хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн болно.

Үр дүн

Бид шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээнд хамрагдагсдын шинжилгээний дүгнэлтэд баримтын судалгаа хийж хүүхэд, өсвөр насныхны эсрэг хүчирхийлэл үйлдсэн 1067 тохиолдлыг сонгон судаллаа.

Table 1. Demographic characteristic of offenders

Age	Male		Female		Total	
	N	%	n	%	N	%
Under 19	215	21.4	8	12.9	223	20.9
20-29	293	29.1	31	50	324	30.4
30-39	274	27.3	15	24.2	289	27.1
40-49	170	16.9	8	12.9	178	16.7
50 and over	53	5.3	-	-	53	5
	1005*	100	62	100	1067	
Total	94.2		5.8			100
Employment						
Yes		170			15.9	
No		897			84.1	

*P<0.006

Судалгааны үр дүнгийн нэгдүгээр хүснэгтээс үзвэл хүүхэд, өсвөр насныхны эсрэг хүчирхийлэл үйлдэгчдийн дотор 20-29 насны хүмүүс (n=324, 30.4%), хүйсийн хувьд эрэгтэйчүүд илүү хувийг (94.2%) эзэлж байгаа бөгөөд эрэгтэйчүүд хүчирхийлэл илүүтэй үйлддэг болох нь статистик ач холбогдол бүхий байна (p<0.006).

Бидний судалгаанд хамрагдсан хүчирхийлэл үйлдсэн хүмүүсийн 84.1% нь тодорхой эрхэлсэн

ажилгүй байгаа нь анхаарал татаж байгаа боловч ажилгүйдэл нь хүчирхийлэл үйлдэхэд хүчтэй нөлөөлөхгүй байгаа нь статистик үзүүлэлтээр батлагдав (p<0.433). ДЭМБ-ын ангиллын дагуу 0-9 насныг хүүхэд нас, 10-19 насныг өсвөр нас хэмээн ангилдаг тул хүчирхийлэлд өртөгсдийн насныг энэ ангиллын дагуу судлан үзэв (Хүснэгт 2).

Table 2. Age, gender and health condition of victims

Victims of sexual violence	Indicators		
		N	%
Age	0-9 y.o	312	29.2
	10-19 y.o	755	70.3
Gender	Boys	106	9.9
	Girls	961*	90.1
Health condition	Healthy	991	92.9
	Somatic health problems	4	0.4
	Mental health problems	72	6.7

p<0.000

Бидний судалгаанд хамрагдагсдын олонх нь (70.3%) өсвөр насныхан байгаа ба хүйсийн хувьд охидууд хүчирхийлэлд илүүтэй (n=961, 90.1%) өртөж байгаа нь статистик ач холбогдол (P<0.000) бүхий магадлалтай байна.

Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээний баримтаас үзвэл судалгаанд

хамрагдсан хохирогчдын 92.9% нь хүчирхийлэлд өртөх үедээ эрүүл, 0.4% нь бие махбодын өвчтэй байсан бол сэтгэцийн өвчтэй хүүхэд харьцангуй бага (n=72; 6.7%) хувийг эзэлж байлаа. Хохирогчийн сэтгэцийн эмгэгийн оношийг судлан үзвэл бүгд оюуны хомсдолтой байсан болох нь тогтоогджээ.




Figure 1. Age group of abused child and adolescents by gender

Нэгдүгээр зургаас үзвэл өсвөр насны хөвгүүд хүчирхийлэлд харьцангуй бага өртөж байгаа бол өсвөр насны охид хүчирхийлэлд илүү их (n=696, 72.4%) өртөж байна.

Table 3. Types of violence and some influencing factors

Indicators	Types of violence						N	%
	Age group	Sexual	Neglect	Financial	Psycho logical	Physical		
Age group of offenders	>19	187	2	2	1	31	223	20.9
	20-29	266	9	2	2	45	324	30.4
	30-39	247	5	-	1	36	289	27.2
	40-49	156	2	1	-	19	178	16.6
	50<	48	-	1	-	4	53	4.9
Total	n	904	18	6	4	135	1067	100
	%	84.7	1.7	0.6	0.4	12.6	100	
Have offender used alcohol	Yes	402	-	2	-	38	442*	41.4
	No	502	18	4	4	97	625	58.6
Total		904	18	6	4	135	1067	100

*P< 0.000

Хүснэгт 3-аас хүүхэд, өсвөр насныхны эсрэг хүчирхийллийн хэлбэрийг нарийвчлан үзэхэд бэлгийн хүчирхийлэл хамгийн их буюу 84.7%-ийг, бие махбодын хүчирхийлэл 12.6% (n=135)–ийг тус тус эзэлж байв. Хүчирхийлэл үйлдэгчийн нас, үйлдэж буй хүчирхийллийн хоорондын хамаарлыг судлан үзвэл хүчирхийллийн хэлбэр, хүчирхийлэл үйлдэгчийн нас хамааралгүй болох нь статистик үзүүлэлтээр батлагдав. Харин хүчирхийлэлд өртөхөд хүүхдийн хүйс нөлөөлж байлаа. Тухайлбал: бэлгийн хүчирхийлэлд охид илүү өртөж байгаа нь статистик үнэн магадтай батлагдав (P<0.000).

Баримтын судалгааны дүнгээс үзэхэд хүчирхийлэл үйлдэгчдийн 41.4% нь хүчирхийлэл

үйлдэхдээ согтууруулах ундаа хэрэглэсэн гэж мэдүүлсэн бөгөөд хүчирхийлэл үйлдэхэд архины хэрэглээ нөлөөлдөг болох нь статистик ач холбогдолтой төдийгүй энгийн логистик регрессийн аргаар судлан үзэхэд архи хэрэглэх нь бэлгийн хүчирхийлэл үйлдэх эрсдэлийг 2.35 дахин нэмэгдүүлдэг ажээ (OR=2.355; p<0.000; CI 95%; 1.601-3.463).

Хүүхэд, өсвөр насныхны эсрэг хүчирхийллийн дотор бэлгийн хүчирхийлэл хамгийн их хувийг эзэлж байгаа тул бэлгийн хүчирхийлэлд хамаарах хэлбэрүүдийг нарийвчлан судаллаа.




Figure 2. Types of sexual violence among child and adolescent (by number of cases and gender)

Судалгааны үр дүнгээс үзвэл хөвгүүд бэлгийн хүчирхийлэлд өртсөн нийт 19 тохиолдлын 10 нь ижил хүйсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн ба ижил хүйсийн хүчирхийлэлд хөвгүүд охидоос илүү өртдөг болох нь статистик ач холбогдол бүхий хамааралтай байв (p<0.000).

Бидний судалгааны дүнгээс үзвэл нийт судалгаанд хамрагдсан тохиолдлын дотор хүүхэд, өсвөр насны охид хүчирхийлэлд өртөх нь хамгийн их хувийг эзэлж байгаа учир хүчирхийллийн хэлбэрээр нь нарийвчлан үзвэл судалгаанд хамрагдсан охидын 92.1% (n=961) нь зөвхөн бэлгийн хүчирхийлэлд өртжээ.




Figure 3. Causes lead to child maltreatment

Гуравдугаар зургаас үзвэл хүүхдийг орой үдэш ганцааранг нь явуулах (21.8%), согтуу хүнтэй хамт орхих (19.4%), хүүхдээ айлд орхих (15.5%) зэрэг шалтгаанууд нь хүүхэд хүчирхийлэлд өртөхөд нөлөөлөх хүчин зүйл болж байна. Дээрх зургаас харахад гэр бүлийн маргаан харьцангуй цөөн хувийг эзэлж байгаа хэдий ч энгийн логистик регрессийн аргаар судлахад гэр бүлийн гишүүд, ялангуяа эцэг, эх нь хоорондоо маргаантай байхад хүүхэд, өсвөр насныхан бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлт хүчин зүйл болох магадлал гэр бүлийн маргаангүй гэр бүлээс 3.7 дахин их байдаг болох нь статистик ач холбогдол бүхий хамааралтай байлаа (OR=3.723; p<0.000; CI 95%-2.356-5.883). Түүнчлэн бидний судалгаагаар нийт тохиолдлын дотор гэр бүл салалт 11.8%-ийг (n=126) эзэлж байгаа ба энгийн логистик регрессийн аргаар хамаарлыг судлахад хүүхэд, өсвөр насныхан бэлгийн хүчирхийлэлд өртөхөд гэр бүл салалт нөлөөлөх хүчин зүйл болж байна (OR= 0.419; p<0.015, CI 95%- 0.208-0.844).

Хүүхэд, өсвөр насныхны эсрэг хүчирхийлэл үйлдсэний улмаас хүүхдийн эрүүл мэнд, амь насанд учирсан хохирлыг баримтанд тэмдэглэгдсэнээр ангилан тавдугаар зургаар илэрхийллээ.

Зургаас үзвэл бэлгийн хүчирхийлэлтэй холбоотойгоор бэлэг эрхтэний гэмтэл, урагдал, цус алдалт, бэлгийн замын халдварт өвчнөөр өвчлөх, жирэмслэх зэрэг эрүүл мэндийн хохирол учирсан бол биемахбодын хүчирхийллийн улмаас амь насаа алдсан тохиолдол 7.2 % (n=77)-ийг эзэлж байна.




Figure 4. Health damages of victims related to violence

Хүүхэд, өсвөр насныхны эсрэг хүчирхийлэл үйлдэж буй хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тогтоосон шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээний дүгнэлтээс үзвэл сэтгэцийн хувьд эрүүл, үйлдсэн хэргээ хариуцах чадвартай хүмүүс ихэвчлэн хүчирхийлэл үйлдэж байгаа нь статистик ач холбогдол бүхий магадлалтай болох нь тогтоогдов (90.5%; p<0.000).

Бид судалгаанд хамрагдсан нийт тохиолдлын дотор хүчирхийллийг хэн, ямар хэлбэрээр үйлддэг болохыг уялдуулан судлахад хүчирхийллийн хэлбэрүүдээс хүүхэд, өсвөр насныхны эсрэг бэлгийн хүчирхийлэл илүүтэй (84.7%) байгаа бөгөөд хүчирхийллийн 75.5% (n=683)-ийг хүүхдийн ойр дотны, таньдаг хүн үйлдсэн нь статистик ач холбогдол бүхий хамааралтай байна (p<0.000).

Хүчирхийллийн давтамжийг судлан үзвэл хүчирхийлэл үйлдэгчдийн 80.3 % нь (n= 857) нэг удаа хүчирхийлэл үйлдсэн, 19.7% нь 2 ба түүнээс дээш олон удаа давтагдсан байв. Энэхүү судалгааны дүнгээс үзвэл төрсөн эцэг нь охиноо

хүчирхийлсэн 58 (6.4%) тохиолдол, охидыг хойд эцэг нь хүчирхийлсэн 149 тохиолдол, цусан төрлийн хамаатан нь хүчирхийлсэн 23 (2.5%) тохиолдол буюу нийтдээ бэлгийн хүчирхийлэл (n=904) дотор 8.9%-ийг цусан төрлийн холбоотой хүмүүсийн хүчирхийлэл эзэлжээ.

Бид судалгаанд хамрагдагсдын хүчирхийлэгчийн эсрэг эсэргүүцэл үзүүлсэн эсэхийг баримтаас судлан үзэхэд бэлгийн хүчирхийлэлд өртөгсдийн 41.6% нь идэвхитэй эсэргүүцсэн, 54.9% нь зөвхөн хүчирхийлэгчийн шаардлагыг даган биелүүлсэн, ямар нэг хэлбэрээр эсэргүүцэх оролдлого хийгээгүй байдал харагдаж байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдсэн орчныг судлан үзэхэд нийт тохиолдлын ихэнх хувь нь буюу 48.8 % нь ахуйн хүрээнд буюу хохирогчийн гэрт үйлдэгдсэн, 36.5 % нь хүүхэд бусдаас тусламж авах боломжгүй хүнгүй газар үйлдэгджээ.

Хэлцэмж

Дэлхий дахинаа хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь нийгэм, эрүүл мэнд, сэтгэлзүйн тулгамдсан асуудлын нэг болсон бөгөөд ялангуяа хүүхэд хүчирхийлэлд өртөх нь хоруу чанар ихтэй үзэгдэл юм. Хэвлэлийн тоймоос үзвэл хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх судалгааг ямар байгууллагыг түшиглэн ямар аргаар хийснээс хамааран харилцан адилгүй үр дүн гардаг байна.

Тухайлбал, Канадад 2000- 2001 онд 1893 хүүхэд хамруулсан сургуульд суурилсан судалгаагаар 26.1% нь биемахбодын хүчирхийлэлд, 10.1% нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн байсан бол олон улсад хийсэн судалгаагаар Барбадост эцэг эхийн 70% нь хүүхдээ тэлээ бүсээр зоддог, Солонгосын хүүхэд хамгааллын холбооны судалгаагаар хүүхдүүдийн 97% нь биемахбодын шийтгэл амсаж байсан, Румыны эцэг эхчүүдийн 84% нь хүүхдийг бөгсөн дээр нь алгадах нь энгийн үзэгдэл гэж хариулсан үр дүнгүүд байна [10].

Бидний энэ удаагийн судалгаагаар хүүхдийн эсрэг хүчирхийллийн 1067 тохиолдлыг судлан үзвэл, 84.7% нь бэлгийн хүчирхийлэл, 16.3% нь бусад хэлбэрийн хүчирхийлэл байлаа. Бидний судалгаа нь СЭМҮТ-ийн Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэсэн, эрүүгийн хэрэг үүсгэгдсэн тохиолдлуудад суурилсан тул биемахбодын хүчирхийллээс илүүтэй бэлгийн хүчирхийлэл илүү бүртгэгдсэн гэж үзэж байна. Хэдийгээр хуулийн байгууллагад бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж бүртгэгдсэн ч гэсэн ямар ч хүчирхийллийн цаана бие махбодын болон сэтгэл санааны хохирол ямар нэг хэмжээгээр үүссэн гэж бид үзэж байгаа юм.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлд “хүүхдийн бэлэг эрхтэнээр оролдох, амаар үйлдэл хийх зорилгоор хүүхдийн биеийг илж таалах, үтрээ шулуун гэдэс рүү нь хуруу, бэлэг эрхтэнээ эсвэл бусад ямар нэг зүйл хийх, насанд хүрсэн хүний бэлэг эрхтэн үзүүлэх, бэлгийн харьцаанд орох санал тавих зэрэг олон үйлдэл багтдаг” байна[11]. Манай улсад хийсэн зарим судалгаанаас үзвэл хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс (2010) 20 хүүхдэд тохиолдлын судалгаа хийж үзэхэд 13.6% нь төрсөн эцэг нь хүчирхийлсэн, 25% нь жирэмсэлж үр хөндүүлсэн, 70% нь бэлгийн замын халдварт өвчнөөр өвчилсөн [12], Ц.Цолмон, Д.Бадамдорж (2010) нарын 117 кейс судалгаанд хамрагдагсдын 34.1% нь бэлгийн хүчирхийлэлд үүний дотор 35%-ийг төрсөн эцэг нь үйлдсэн байсан бол 13 зарим судалгаанд хүчингийн гэмт хэргийн 26.6%-ийг ураг төрлийн хүчин эзэлдэг (И.Тэгшээхүү, 2011) [14] зэрэг олон судалгаа байна.

Бидний судалгаагаар нийт тохиолдлын 84.7% нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн байсан бөгөөд хүйсийн хувьд авч үзвэл 2.1% нь эрэгтэй, 97.9% нь хүүхэд, өсвөр насны эмэгтэйчүүд байна. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн эрэгтэй хүүхдүүдийн 10 тохиолдолд ижил хүйсийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Бэлгийн хүчирхийлэлд охид хөвгүүдээс илүү их өртдөг хэдий ч хөвгүүд голдуу хүчирхийлэгчийн ижил хүйстнээ сонирхох бэлгийн чиг баримжаатай холбоотойгоор ижил хүйсийн хүчирхийлэлд өртөх тохиолдол байдаг бөгөөд эрэгтэй хүүхдүүд өөрийгөө хамгаалж чадаагүйдээ эмзэглэж сэтгэлзүйн гэмтэлд давхар өртдөг ажээ [11].

Бэлгийн хүчирхийллийн нэг өвөрмөц хэлбэр нь цусан төрлийн холбоотой хүмүүсийн бэлгийн хүчирхийлэл буюу инцест юм. Бидний судалгаагаар нийт тохиолдлын 8.9%-ийг цусан төрлийн холбоотой хүмүүсийн хүчирхийлэл эзэлж байгаа ба төрсөн эцэг нь охиноо хүчирхийлсэн 58 тохиолдол байлаа. Энэхүү үзүүлэлт нь бусад судлаачдын судалгааны үр дүнтэй ойролцоо гэж үзэж болохоор байна. Хүүхэд, өсвөр насныхан бэлгийн хүчирхийлэлд өртсөнтэй холбоотойгоор бэлэгэрхтэний гэмтэл, урагдал, цусалдалт, бэлгийн замын халдварт өвчнөөр өвчлөх, жирэмслэх зэрэг хүүхдийн биеийн эрүүл мэндэд учирсан хохирлыг тэмдэглэсэн боловч сэтгэл санааны хохирлын талаар огт дурьдагдаагүй, 4% нь хүчирхийлэлд өртсөний улмаас сэтгэцийн эмгэгтэй болсон гэх боловч сэтгэцийн ямар өөрчлөлт илэрсэн талаар тодорхой тэмдэглэгдээгүй байлаа.

Судалгааны дүнгээс үзвэл хүүхэд, өсвөр насныхны эсрэг хүчирхийллийг ихэнхидээ эрэгтэйчүүд, архи

хэрэглэсэн үедээ үйлдэж байгаа ба хүүхэд, өсвөр насныхан бэлгийн хүчирхийлэлд өртөхөд гэр бүл салалт, гэр бүлийн доторхи сөрөг харилцаа, хүүхдэд тавих хараа хяналт сулрах байдлууд нөлөөлж хүүхэд сэтгэл санаа, биемахбод, эрүүл мэндээрээ давхар хохиролд өртөж байна.

Иймд хүүхэд, өсвөр насныхны эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд, түүнд нөлөөлөх хүчин зүйл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх боломжийн талаар нэгдмэл, цогц судалгаа хийх шаардлагатай гэж үзэж байна.

Дүгнэлт:

1. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээний материалаас үзвэл хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд дотор хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл илүүтэй (84.7%) байна.
2. Хүүхэд, өсвөр насныхны эсрэг хүчирхийлэл дотор хөвгүүд ижил хүйсийн хүчирхийлэлд (52.6%, $p < 0.000$), охид бэлгийн хүчирхийлэлд өртөх нь илүү (97.9 %, $p < 0.000$) байна.
3. Охид бэлгийн хүчирхийлэлд өртөхөд хүчирхийлэгч архи хэрэглэсэн байх (OR=2.355; $p < 0.000$; CI 95%; 1.601-3.463), гэр бүлийн доторхи сөрөг харилцаа (OR=3.723; $p < 0.000$; CI 95%-2.356-5.883), гэр бүл салалт нөлөөлж байна.

Ном зүй

1. Хүүхдийн эрхийн тухай конвенци. www. Legal.info.mn. 2012
2. “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” Монгол улсын хууль. УБ.2003
3. Krug et al., “World report on violence and health”, World Health Organization, 2002
4. Одонтуяа Д. Монголд гэр бүлийн хүчирхийллийн талаар асуумж авч судалсан байдал. Онош. 2002. №1 (013). х.1-4
5. Tracie O. Afifi, Harriet L. MacMillan, Michael Boyle, Tamara Taillieu. Child abuse and mental disorders in Canada. CMAJ, June 10, 2014, 186(9)

6. Child abuse and neglect by parents and other caregivers. Chapter 3. www.who.int/violence-injury. 2000
7. Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. Бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдэд хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх арга зүйн туршилт. УБ. 2010. х-5
8. Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. Бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдийн эрхзүйн хамгаалалтыг сайжруулах нь. УБ. 2010. х.16-17
9. Ludovica Laccino. Child sexual abuse: Top 5 countries with the highest rates. www.ibtimes.co.uk/child-sexual-abuse
10. Http://www.Info@endcorporalpunishment.org. “Хүнийг цохих буруу- хүүхэд ч гэсэн хүн шүү дээ”. 2011
11. Мягмар О. Сэтгэц заслын зөвлөгөөний арга зүй. УБ.2009. х.60
12. Mongolian marketing consulting group. Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар. Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа-2014. УБ. 2014. х. 32
13. Цолмон Ц., Бадамдорж Д. Өрх доторх хүүхэд хамгаалал. Ураг төрлийн хүчин. www.sochialwork.mn.Apr. 2010.
14. Тэгшээхүү И. Хүүхэд хамгааллын асуудал нийгмийн тулгамдсан асуудал болох нь. www.Tenger.edu.mn

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Анагаах ухааны доктор, профессор Г.Цагаанхүү*